

Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Равдан Цэдэв

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1		2	3	4	5	6	7
1.1. Орон нутгийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжинэ.							
1	Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх сургалт, арга хэмжээ зохион байгуулах,	сургалт арга хэмжээ зохион байгуулсан байна.	2 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулж ажилласан.	1 удаагийн сургалт арга хэмжээ зохион байгуулсан байна.	-Орон нутаг дахь брэнд бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зорилгоор Enguun.mn сайт-тай хамтран бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаар нэвтрүүлэг бэлтгэж орон нутгийн телевиз болон нийтийн мэдээллийн сувгуудаар цацалт хийн ажилласан. Бэлгийн багц гаргах зорилгоор 30 хоногийн хугацаатай уралдаан зарлан хүнсний үйлдвэрийн 3 аж ахуйн нэгж, хөнгөн үйлдвэрийн 2 аж ахуйн нэгж шалгарч нийт 10,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Аймгийн	5-р сар, 6-р сар	100%

					хэмжээнд брэнд бүтээгдэхүүний сургалтанд хамрагдсан нийт 20 аж ахуйн нэгжээс 8 аж ахуйн нэгжийг сонголтоор авч брэндийн чиглэлээр мэргэшсэн багш урьж сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Үүний үр дүнд шүхрэн брэндийг хэрхэн бий болгох, бэлгийн багц гаргах 5 аж ахуйн нэгжийг шалгаруулж сав баглаа боодлын дэмжлэг үзүүлэн 10,0 сая төгрөг олгосон. -Улаанбаатар хот Налайх дүүрэгт зохион байгуулагдсан Нүүдэлчин 2024” дэлхийн соёлын фестивальд Орхон аймгаас Өндөрлөг брэнд / арьсан урлал/, Сампин брэнд, Угалз брэнд, Жигүүр брэнд, цайны брэнд амжилттай оролцож бараа бүтээгдэхүүнээ сурталчилсан. - Брэнд бүтээгдэхүүнийг нутагшуулах, хөгжүүлэх чиглэлээр гар урлалын уралдаан зарлаж "Өндөрлөг брэнд" шилдгийн шилдэгээр шалгарч цом мөнгөн шагнал, Сампин брэнд "		
--	--	--	--	--	---	--	--

					Гоо дагина" бүтээлээрээ шилдэг урлангаар шалгарч гутгаар шагналын эзнээр тодорлоо.		
2	Оёдлын үйлдвэр, эрхлэгчдийг чадавхижуулах сургалт арга хэмжээ зохион байгуулах	Сургалт зохион байгуулж чадавхижуулсан байна.	2 удаагийн чадавхижуулах сургалт зохион байгуулсан.	1 удаагийн сургалт зохион байгуулсан байна.	-Оёдлын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх чиглэлээр Хөгжлийн шийдэл ТББ-ын BEST хөтөлбөртэй хамтран 11 удаагийн сургалт, арга хэмжээг онол практик хосолсон байдлаар зохион байгуулж амжилттай оролцсон аж ахуйн нэгжүүдэд чадамжийн СЕРТИФИКАТ гардууллаа. Сургалтанд 25 иргэн аж ахуйн нэгж хамрагдлаа. -Сургалт, арга хэмжээний үр дүнд идэвхигүй байсан мэргэжлийн холбоогоо идэвхижүүлж удирдах зөвлөлөө шинэчлэн гишүүнчлэлээ нэмэгдүүлснээр салбарын үйл ажиллагаа идэвхижиж дараагийн ажлуудаа төлөвлөн 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож, Улаанбаатархот, БНХАУ-ын Эрээн Хөх хотын оёдлын үйлдвэрийн туршлага судлах арга	3-р сар, 4-р сар	100%

					хэмжээг байгуулан үзүүлэн ажиллаж байна.	зохион дэмжлэг байна.	
1.2. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээний салбарыг санхүүгийн болон санхүүгийн бус хэлбэрээр дэмжин ажиллах							
3	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаанд оролцуулах	борлуулалтыг дэмжин ажиллах	3 удаагийн үзэсгэлэн худалдаанд 150 гаруй үйлдвэрлэгчдийг оролцуулсан	1 удаагийн үзэсгэлэнд оролцуулсан байна.	-2024 онд “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж орон нутгийн 70 гаруй бизнес эрхлэгчид, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан 3 үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 5 аж ахуйн нэгжийг зохион байгуулалтаар оролцуулсан. -Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд бизнес хийх таатай орчин бүрдүүлэх зорилгоор орон нутгаас зохион байгуулсан 2 удаагийн үзэсгэлэн худалдаанд талбайн түрээсийн хөнгөлөлт үзүүлэн 40 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан оролцуулсан. -Нүүдэлчин 2024” дэлхийн соёлын фестиваль Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Тайж хайрхан”-ы бэлд 21 аймаг 9 дүүрэг, 17 гадаадын улс орны 80 гаруй иргэний	1-р сар, 2-р сар, 10-р сар	100%

					оролцоотой зохион байгуулагдлаа. Орхон аймгаас урлаг, уран бүтээл, өв соёл, нүүдлийн ёс заншлыг харуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй хамтарсан баг оролцсон. Үндэсний дээл хувцас арьсан эдлэл, хивс, хивсэн бүтээгдэхүүн, гоёл чимэглэл, давсан урлал, мөн нүүдлийн цайны соёлыг сурталчилан 10 гаруй жижиг дунд үйлдвэр эрхлэгчид үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээрээ 80 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж 60,0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. -Эрээн хотын Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын 6 өдөр үргэлжлэх үзэсгэлэн худалдаанд, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран, оролцох аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр ханган бүртгэж оролцуулсан. Орон нутгаас уран зураг, ноос ноолуур, арьсан эдлэл, үндэсний дээл хувцас		
--	--	--	--	--	--	--	--

					үйлдвэрлэдэг 4 аж ахуйн нэгж оролцож 200,0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. - Намрын ногоон өдрүүд үндэсний үйлдвэрлэл-2024 өргөтгөсөн үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хот төв цэнгэлдэх хүрээлэнд 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Орхон аймгаас хүнс, хөнгөн, газар тариалангийн чиглэлийн 12 иргэн, аж ахуйн нэгж оролцож 23,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. - Дархан хотод болсон бүсийн арга хэмжээнд Орхон аймгаас 4 аж ахуйн нэгж оролцож өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ сурталчилан 45,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.		
4	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах.	зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	32 аж ахуйн нэгжид 1,5 тэрбум төгрөгийн зээл олгосон.	Зээлд хамрагдсан байна.	ХХААХҮ-ийн сайдын А/28 дугаар тушаалаар батлагдсан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс олгох хөнгөлөлттэй зээлийн зориулалтаар Орхон аймагт 1,0 тэрбум төгрөг батлагдсан. 21	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					салбар, чиглэлд үндсэн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зориулалтаар 5 жилийн хугацаатай, жилийн 3 хувийн хүүтэй, үндсэн төлбөрөөс 1 жил хүртэл чөлөөлөх нөхцөлөөр олгож байна. Төслийг хуанлын 30 хоногийн хугацаанд цахим систем ашиглан, 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 8 төсөл хүлээн авч дэд хорооны хурлаар 674,0 сая төгрөгийн санхүүжилт хүссэн 4 төслийг хэлэлцэн шийдвэрлэж жагсаалтыг Засаг даргын захирамжаар баталгаажуулан Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн. Барьцаа хөрөнгийн үнэлгээ, эрсдлийн даатгал хийлгэж санхүүжилтийг олгосон. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 400,0 сая, орон нутгийн төсвөөс 400,0 сая төгрөг нийт 800,0 сая төгрөгийн эх үүсвэртэй зээл гаргахаар хуанлын 30 хоногийн хугацаанд цахим систем ашиглан зарласан. Цахим системд 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилт		
--	--	--	--	--	---	--	--

					хүссэн 11 төсөл ирснийг судалж үзээд 597,5 сая төгрөгийн санхүүжилт хүссэн, МAA-н 2, авто засвар үйлчилгээний -1, гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн-1 нийт 4 төслийг аймгийн дэд хорооны хурлаар оруулж хэлэлцэн санхүүжилтийг олгохоор шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд хүнс, хөнгөн, газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн 8 аж ахуйн нэгжид 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 онд 3 хоршоонд 250,0 сая төгрөгийн зээл олгосон.		
5	Зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийж, үйлдвэрийн үйл ажиллагааг сурталчилсан байна.	хяналт шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгжийн тоо	15 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийж үйлдвэрийн ажиллагааг сурталчилж ажилласан.	аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт хийж үйлдвэрийн үйл ажиллагааг сурталчилж ажилласан.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2024-04-10-ны өдрийн А/77 тоот тушаал, ХХААГ-ын даргын 2024-10-04-ний өдрийн удирдамжийн дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт мониторинг хийсэн. Зээлийн хяналт	9-р сар, 10-р сар	100%

					шалгалтаар төслийн санхүүжилтийн зарцуулалт, эргэн төлөлт, үр дүн, орлого ашгийн харьцаа зэргийг хяналтын тайлангийн маягтаар мэдээллийг авч зээлийн системийн нэгдсэн программд шивэлт хийж байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019 оноос хойш 28 зээлдэгчдэд 3,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. ХХААГ-ын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн хяналт хийх ажлын удирдамж гарган ажилласан. Зээлийн эргэн төлөлт болон үйл ажиллагаанд жил бүр хяналт мониторинг хийж, тайланг Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлэн, тайлагнаж байна. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсанаар үйлдвэрүүд орчин үеийн шинэ тоног төхөөрөмжтэй болсон, ажлын байраа өргөтгөж тохижуулсан, түүхий эдийн нөөцтэй болсон зэрэг сайн үр дүнгүүд гарсан. Нэг аж ахуйн нэгжийн санхүүжилт		
--	--	--	--	--	--	--	--

					дутуу орсноос төслийн үйл ажиллагаа хэрэгжээгүй. Үүнийг Жижиг дунд үйлдвэрийн Хууль тусгай активын хэлтэст шилжүүлж холбогдох арга хэмжээг авч зээлийг бүрэн төлүүлж хаалгасан. Бусад аж ахуйн нэгжийн зээлийн эргэн төлөлт хэвийн, үйл ажиллагаа тогтмол явагдаж байна. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд хамрагдаж үйлдвэрийн үйл ажиллагаагаа өргөжүүлж амжилттай яваа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчилан орон нутгийн телевизтэй хамтран тусгай нэвтрүүлэг бэлтгэн ЖДҮ эрхлэгчдийн 7,8 мянган гишүүнчлэлтэй 2 төрлийн facebook групп, байгууллагын пэйж хуудас, орон нутгийн телевизээр цацалт хийн ажиллаж байна.		
2.1. Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлэх аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг хангах							
6	Жижиг, дунд үйлдвэрлэл	Жижиг дунд үйлдвэр	2023 онд нийт 150 гаруй аж ахуйн	зөвлөгөө мэдээлэл өгч	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн	1-р сар, 2-р сар, 3-р	

btl

	эрхлэгчээр бүртгүүлэх аж ахуйн нэгжид тавигдах шаардлагын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, тодорхойлолт олгох	үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөгөө мэдээлэл өгч тодорхойлолт олгосон байна.	нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч, 65 аж ахуйн нэгжид тодорхойлолт олгосон байна.	тодорхойлолт олгосон байна.	сайдын А-156 дугаар тушаалаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэж, тодорхойлолт олгох ажлыг аймгийн ХХААГ-т шилжүүлснээр орон нутагт бүртгэн, мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. 2021 оноос эхлэн e-mongolia цахим системээр дамжуулан Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлэх боломжтой болсон. Хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагыг жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3 заалтыг хангаж байгаа эсэхийг харгалзан үзэж бүрдүүлэх материалын жагсаалтыг үндэслэн бүртгэж тодорхойлолт олгож байна. Жилд дунджаар 80-120 аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэн, тодорхойлолт олгон ажилласан. 2024 онд 85 аж ахуйн нэгжид зөвлөгөө мэдээлэл өгч, 2 төрлийн гарын авлагаар ханган жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчээр бүртгэн	сар, 4-р сар, 6-р сар, 10-р сар, 11-р сар	100%
--	---	--	--	-----------------------------	--	---	------

					тодорхойлолт олгосон.		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
7	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар, улирал, хагас, бүтэн жилээр боловсруулан гаргаж, батлуулан ажиллаж байна. - Төлөвлөгөөний биелэлтийг сар бүр гаргаж, баталгаажуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна. - Хариуцсан салбаруудтай холбоотой бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг цаг тухай бүрд нь гаргаж ҮХҮ-ний албаны даргаар баталгаажуулан холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон				Иргэдээс Төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй. Бусад байгууллага албан газраас ирсэн бичгийн хариуг цаг тухайд нь хүргүүлэн ажилласан. Өмнөх оны бичиг баримтыг цэгцэлж 8 боть мемориал болгон	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				үдэж архивын ажилтанд хүлээлгэн өгөв.		
--	--	--	--	---------------------------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Хариуцан ажиллаж байгаа салбартай холбогдон гарсан хууль тогтоомжийн өөрчлөлтийг судлан бүхий л чиглэлээр өөрийгөө хөгжүүлэн суралцана.	Холбогдох сургалтуудад хамрагдах	3 удаагийн сургалтанд амжилттай оролцож Батламж гэрчилгээтэй төгссөн.	Холбогдох сургалтуудад хамрагдах	Хариуцсан салбарын хүрээнд ахиц дэвшил гаргаж өөрийгөө хөгжүүлэх зорилгоор 2 удаагийн сургалтанд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлээ.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Равдан Цэдэв /...../

Огноо: 2024.05.05